



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 5/Н

Хэрлэн сум

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.1.1, Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хэнтий аймгийн Аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийгдсэн нийцлийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг дутуу байршуулдаг, хуулийн хугацааг баримтлахгүй, хугацаа хоцроож мэдээллийг хангалтгүй байршуулсан Норовлин сумын Засаг дарга П.Алтангэрэлд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

Хоёр. Албан үүргээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Норовлин сумын Засаг дарга П.Алтангэрэлд үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБ